

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2007 оны 12 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 206

Улаанбаатар хот

Үнэт цаасны мэдээллийн нэгдсэн
сангийн журам батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.2, 34.1.3 дахь заалтыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Үнэт цаасны мэдээллийн нэгдсэн сангийн журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, мэдээллийн санд төвлөрүүлэх мэдээллийн жагсаалт, мэдээлэл ирүүлэх хугацаа, Хорооноос нийтэд мэдээлэх мэдээллийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү журмыг 2008 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс дагаж мөрдсүгэй.

3. Энэхүү журмыг зах зээлийн нийт оролцогчдод сурталчлан танилцуулж, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/-т даалгасугай.

4. 2008 оны 1 дүгээр улиралд багтаан өөрийн байгууллагын үйл ажиллагааны талаар нийтэд мэдээлэл хүргэх боломж бүрдүүлсэн вэб хуудастай болохыг үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогч нийт байгууллагад үүрэг болгосугай.

5. Энэ журам батлагдсантай холбогдуулан Үнэт цаасны хорооны /хуучнаар/ 2003 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 14 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралт, 2003 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 45 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн санхүүгийн тайлан тэнцлийн хураангуйг хэвлэн нийтлэх, мэдээллийг нийтэд хүргэх журам”-ын хоёрдугаар хэсэг, 2003 оны 6 дугаар сарын 06-ны өдрийн 46 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГИЙН ТУХАЙ ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь хууль тогтоомжоор хүлээсэн үүргийнхээ дагуу үнэт цаасны зах зээлийн оролцогчдоос Санхүүгийн зохицуулах хороон дахь Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сан (цаашид “Мэдээллийн сан” гэх)-д ирүүлэх мэдээллийн төрөл, хуваарийг тогтоон, холбогдох мэдээллийг хүлээн авах, мэдээллийг боловсруулах, хянах, хадгалах, мэдээллийн сан дахь мэдээллийг ашиглах, олон нийтэд мэдээлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Үнэт цаасны зах зээлийн оролцогчид /мэргэжлийн оролцогч болон үнэт цаас гаргагчид/ нь энэхүү журмаар тогтоосон мэдээллийг үнэн зөвөөр тогтоосон хугацаанд багтаан гаргаж, мэдээллийг бичгэн хэлбэрээр /тус Хорооноос шаардлагатай гэж үзсэн тохиолдолд цахим хэлбэрээр / Хорооны Ажлын албаны мэдээллийн сан хариуцсан албан тушаалтанд хүргүүлнэ.

1.3. Хууль тогтоомж болон энэхүү журмаар нийтийн хүртээл болгохоор тогтоосон мэдээллийг уг мэдээлэл гаргасан этгээд аливаа саадгүйгээр өөрийн байгууллага, түүний мэдээллийн хэрэгслээр дамжуулан тухай бүр хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдэд гаргаж өгөх үүрэгтэй.

1.4. Үнэт цаасны мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж буй байгууллага, 200-гаас дээш тооны үнэт цаас эзэмшигчтэй, эсвэл үнэт цаас эзэмшигчдийн 30-аас дээш хувь нь нэгээс дээш тооны аймагт оршин суудаг үнэт цаас гаргагч тус бүр өөрийн веб хуудастай байх ба нийтийн хүртээл болгохоор хууль тогтоомж болон энэхүү журмаар тогтоосон мэдээллийг тус Хороонд ирүүлэхийн хамт өөрийн веб хуудсандаа тухай бүр давхар байршуулна.

1.5. Мэдээллийн сангийн өдөр тутмын ажиллагааг эрхлэн хөтлөх, мэдээллийн найдвартай байдлыг хангах, зохих мэдээллийг нийтийн хүртээл болгохтой холбоотой ажлыг тус Хорооны Ажлын алба, түүнээс томилсон нэгж хариуцан гүйцэтгэнэ.

1.6. Мэдээллийн сан дахь мэдээллээс нийтэд тогтмол болон захиалгын дагуу мэдээлнэ.

1.7. Нийтэд тогтмол хүргэх нийтлэг мэдээллийг тус Хорооны веб сайтаар дамжуулан төлбөргүйгээр хүргэх бөгөөд Хороо, үүнийг Ажлын албанаас шаардлагатай гэж үзвэл хэвлэл мэдээллийн боломжит бусад хэлбэрээр нийтэд хүргэж болно.

1.8. Нийтэд тогтмол хүргэх нийтлэг мэдээлэлд хамаарахгүй, эсвэл хамаарах ч тодорхой шүүлт, хайлт, нэгтгэх, дүн шинжилгээ, боловсруулалт зэрэг тодорхой тухайлсан ажиллагаа шаардлагатай мэдээллийг хууль, тогтоомжоор хориглоогүй бол иргэн, хуулийн этгээдийн хүсэлтээр төлбөртэй гаргаж өгч болно. Төлбөрийн хэмжээг Хороо тогтооно.

ХОЁР. Мэдээллийн санд ирүүлэх мэдээллийн төрөл, мэдээлэл ирүүлэх хуваарь

2.1. Мэдээллийн сан дахь мэдээлэл нь үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагууд болон үнэт цаас гаргагчдын талаарх танилцуулга, тэдгээрийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, мэргэжлийн эрх авсан мэргэжилтний талаарх мэдээлэл, үнэт цаасны арилжаа, гүйлгээ, төлбөр тооцоо, үнэт цаасны бүртгэл, үнэ ханш, хадгалалтын талаарх мэдээлэл зэрэг үнэт цаасны зах зээлтэй холбоотой электрон болон бичгэн хэлбэрийн мэдээ, мэдээлэл, тоо баримт, судалгаанаас бүрдэнэ.

2.2. Мэдээллийн санд дор дурдсан иргэн, хуулийн этгээд мэдээлэл ирүүлнэ:

- 2.1.1. үнэт цаасны арилжаа эрхэлж буй байгууллага;
- 2.1.2. үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн үйл ажиллагаа эрхэлж буй байгууллага;
- 2.1.3. брокер, дилерийн үйл ажиллагаа эрхэлж буй байгууллага;
- 2.1.4. андеррайтерийн үйл ажиллагаа эрхэлж буй байгууллага;
- 2.1.5. үнэт цаас гаргагч;
- 2.1.6. хууль тогтоомж, дүрэм журамд заасан бол холбогдох иргэн, хуулийн этгээд.

2.3. Энэхүү журмын 2.2-г заасан иргэн, хуулийн этгээдээс Хороонд ирүүлэх мэдээллийн төрөл болон мэдээлэл ирүүлэх хуваарийн хамт энэхүү журмыг баталсан тогтоолын хоёрдугаар хавсралт ёсоор баталсан жагсаалтаар тогтооно.

2.4. Энэхүү журмын 2.3-г заасан жагсаалтад заасан тодорхой мэдээллийг гаргаж ирүүлэх маягтын загварыг мөн энэхүү журмын хавсралтаар тогтооно.

2.5. Энэхүү журмын хавсралт ёсоор тогтоосноос гадна шаардлагатай гэж үзвэл үнэт цаасны зах зээл, түүний оролцогчидтой холбоотой хэвлэл, телевиз, радио зэрэг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болоод бусад төрлийн мэдээллийн хэрэгслээр гарсан мэдээллийг санд төвлөрүүлж болно.

2.6. Мэдээллийн сан дахь мэдээллийг утга, агуулга, төрөл, хамаарах хуулийн этгээдээр тус бүр бүлэглэн зохион байгуулна.

ГУРАВ. Мэдээллийн санд мэдээлэл хүлээн авах, мэдээллийг боловсруулах, мэдээлэлтэй холбоотой гүйцэтгэх хяналт, Хорооны Ажлын албанаас гүйцэтгэх судалгаа

3.1. Мэдээллийн санд ирүүлэх мэдээллийг энэхүү журмын хавсралтад заасан маягтын дагуу үйлдэж, тухайн мэдээллийн талаар дурдсан албан бичгийн хамт электрон эсхүл бичгэн хэлбэрээр үйлдэж мэдээллийн санд ирүүлэх мэдээллийг хүлээн авах ажил үүргийн хуваарь бүхий мэргэжилтэнд хүргүүлнэ.

3.2. Хороонд ирүүлэх мэдээллийг үнэн зөвөөр зохих журмын дагуу бүрэн гаргаж ирүүлэх ба мэдээллийн үнэн зөв эсэхтэй холбоотой хариуцлагыг мэдээлэл ирүүлсэн иргэн, хуулийн этгээд хүлээнэ.

3.3. Мэдээллийг зохих маягтын дагуу гаргаагүй, эсвэл буруу, алдаатай, бүрдэл дутуу ирүүлсэн мэдээллийг ирүүлсэнд тооцохгүй бөгөөд энэ талаар мэдээллийн этгээдэд албан шаардлага явуулна.

3.4. Хорооны мэдээлэл хүлээн авах Хорооны мэргэжилтэн нь ирүүлсэн мэдээллийг зохих маягтын дагуу гаргасан эсэх, тухайн мэдээллийг ирүүлж буй иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн мэдээллийн тухай тодорхойлсон албан бичигт заагдсан мэдээлэл бүрэн байгаа эсэх, электрон хэлбэрээр ирүүлсэн бол тухайн мэдээллийн файл нь ажиллаж буй эсэх зэрэг урьдчилан тодорхойлж шаардлага хангасан бол хүлээн авна.

3.5. Мэдээлэл хүлээн авсан мэргэжилтэн боловсруулалт болон хяналтын ажиллагаа гүйцэтгэх үүрэг бүхий холбогдох мэргэжилтэнд ажлын 1 хоногт багтаан шилжүүлнэ.

3.6. Боловсруулалт хийх үүрэг бүхий мэргэжилтэн холбогдох мэдээллийг хүлээн авч, үнэн зөв эсэхийг нягталсны үндсэн дээр ажлын 2 хоногт багтаан мэдээллийн санд хадгалах болон нийтэд мэдээлэх хэлбэрт оруулж Хорооны мэдээллийн сан хариуцсан техникийн ажилтанд хүргүүлэхээс гадна тухайн мэдээлэл ирүүлсэн мэргэжлийн байгууллагын хувийн хэрэгт, хувьцаа эзэмшигчийн ирүүлсэн мэдээллийг холбогдох хувьцаат компанийн хувийн хэрэгт хадгалуулахаар уг компанийн хариуцсан мэргэжилтэнд шилжүүлнэ..

3.7. Мэдээлэл нь алдаатай, дутуу, тодруулах шаардлагатай тохиолдолд уг асуудлыг өөрийн удирдлагад танилцуулах замаар хугацааг ажлын 5 хүртэл хоногоор сунгаж болно. Уг хугацаанд холбогдох мэдээлэл ирүүлсэн иргэн, хуулийн этгээдээс тодруулга авч мэдээллийн шаардлагыг хангуулах ба мэдээлэл ирүүлэх үүрэг бүхий иргэн, хуулийн этгээдийн буруутай ажиллагааны улмаас дээрх сунгасан хугацаанд мэдээллийн бүрдлийг хангаж чадаагүй бол тухайн мэдээллийг ирүүлээгүй гэж үзэж тухайн иргэн Хороонд мэдэгдэнэ.

3.8. Мэдээллийн санд ирүүлж буй мэдээлэлтэй холбоотой хяналтын ажиллагааг холбогдох мэргэжилтэн хүлээн авснаас хойш ажлын 5 хоногт гүйцэтгэх бөгөөд ирүүлсэн мэдээлэл нь зөрчилтэй болох нь тогтоогдвол энэ талаар шууд харъяалах удирдлагад танилцуулж холбогдох мэдээллийн зөрчлийг арилгуулах, холбогдох хариуцлага ногдуулах, шаардлагатай гэж үзвэл мэдээллийн санд мэдээллийг хадгалах, нийтэд мэдээлэхийг хойшлуулах арга хэмжээ авна.

3.9. Мэдээллийн санд ирүүлж буй мэдээлэлтэй холбоотой нийтлэг болон тухайлсан хяналтыг Хорооны эрх бүхий нэгж, мэргэжилтэн хариуцан гүйцэтгэнэ.

3.10. Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн мэдээлэлтэй холбоотой дараах нийтлэг хяналтын ажиллагааг гүйцэтгэнэ:

3.10.1. мэдээллийг тогтоосон хугацаанд гаргасан эсэх;

3.10.2. мэдээлэл нь үнэн зөв эсэх;

3.10.3. тухайн мэдээлэл нь бусад иргэн, хуулийн этгээдээс ирүүлдэг бол тэдгээрийн хооронд зөрүү байгаа эсэх, зөрүүтэй бол учир шалтгааныг нь тогтооно;

3.10.4. тухайн мэдээллийг өмнө нь өгч байсан бол түүнтэй нийцэж буй эсэх;

3.10.5. шаардлагатай гэж үзсэн бусад ажиллагаа.

3.11. Үнэт цаасны арилжааны үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагаас ирүүлэх дор дурдсан мэдээлэлтэй холбоотой дараах хяналтын ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.11.1. Анхдагч зах зээлийн арилжааны мэдээнд үндэслэн уг арилжаа Хороонд бүртгэгдсэн графикийн дагуу хийгдэж байгаа эсэх, үнэт цаас гаргагч журмаар тогтоосон хугацаанд тайлан мэдээгээ ирүүлж байгаа эсэх, тухайн үнэт цаас гаргагчийн нийт үнэт цаасны 5-аас дээш хувийн хувьцаа эзэмшигч мэдэгдлээ Хороонд ирүүлсэн эсэх;

3.11.2. Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааны тайлан, ханшийн мэдээг мэдээллийн сан хариуцсан ажилтан өдөр бүр нэгтгэж үнэт цаас гаргагч компани хариуцсан ажилтнуудад тухайн компанийн үнэт цаасны арилжааны мэдээг ажлын 1 өдөрт багтаан шилжүүлэн өгч байна. Компани хариуцсан ажилтан нь уг мэдээнд үндэслэн үнэ ханш нь огцом өөрчлөгдсөн /20-иос дээш хувиар өссөн, буурсан/, арилжааны идэвх гэнэт өөрчлөгдсөн /арилжааны хэмжээ гэнэт өссөн, идэвхитэй арилжаалагдаж байсан үнэт цаасны арилжаа гэнэт зогссон/ зэрэг тохиолдолд шалтгааныг шалгаж, дотоод мэдээлэл ашигласан, эсвэл хуурамч, давхар гүйлгээ хийгдэж байгаа эсэхийг нягтална;

3.11.3. Бүртгэлтэй хувьцаат компанийн үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага дахь бүртгэл, үнэт цаасны арилжаа, ханшийн судалгааг тухайн компанийн хяналтыг хариуцсан мэргэжилтэн сар бүр хүлээн авч хянан мэдээллийг тухайн компанийн хувийн хэрэгт оруулна. Компанийн бүртгэл, бүртгэлийн ангилалд өөрчлөлт гарсан тохиолдолд шалтгааныг судалж тухай бүр дүгнэлт гарган, дүгнэлтийг удирдах албан тушаалтад танилцуулж шаардлагатай арга хэмжээг авна;

3.11.4. Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлд бүртгэгдсэн хувьцаат компаниудын жилийн санхүүгийн тайлангийн нэгтгэлийг дараа оны 3 дугаар сарын 20-ны дотор, хагас жилийн санхүүгийн тайлангийн нэгтгэлийг дараа улирлын 2 дахь сарын 10-ны дотор гарган, дүн шинжилгээ хийж Хорооны удирдлагад танилцуулна;

3.11.5. Ногдол ашиг тараахаар шийдвэрлэсэн хувьцаат компаниудын мэдээллийг Хорооны вэб хуудсанд тогтмол шинэчлэн тавьж байхаас гадна уг мэдээллийг тухайн компани хариуцсан мэргэжилтэн компанийн хувийн хэрэгт оруулж, ногдол ашгийн хуваарилалт, тараалтад хяналт тавина;

3.11.6. Үнэт цаасны арилжааны “ТОП-20” болон салбарын индексийн өөрчлөлтөд сар бүр дүн шинжилгээ хийж, дүнг жилд 2-оос дээш удаа Хорооны удирдлагад танилцуулна;

3.11.7. Гишүүнчлэл бүхий брокер дилерийн компанийн тухай мэдээллийг Хорооны вэб хуудсанд сар бүр шинэчлэн тавьж, тухайн компанийн хувийн хэрэгт оруулахаас гадна дүнг жил, улирлаар нэгтгэн, дүн шинжилгээ хийж, Хорооны удирдлагад танилцуулна;

3.11.8. Хорооны үнэт цаасны бүртгэлд шинээр бүртгэгдсэн үнэт цаасны арилжааны тухай мэдээлэлд үндэслэн Хороонд бүртгэгдсэнээс хойш ямар хугацааны дараа арилжаа эрхлэх байгууллагад бүртгэгдэж байгаа, Хороонд бүртгэгдсэнээс хойш 2-оос дээш долоо хоногийн дараа бүртгэгдсэн, эсвэл 2-оос дээш долоо хоног өнгөрсөн боловч үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэгдээгүй байгаа бол шалтгааныг нягталж, шууд харьяалах удирдлагад мэдээлж байна;

3.11.9. Хороо, түүний улсын байцаагчийн шийдвэрээр арилжааг нь түр зогсоосон, эсвэл сэргээсэн үнэт цаасны талаарх мэдээллийг Хорооны ажлын албанаас гаргасан мэдээлэлтэй тулгаж, зөрүүг тогтоон хяналт тавихаас гадна үнэт цаасны арилжааг түр зогсоосон үндэслэл, шалтгааны судалгааг жил, хагас жилээр Хорооны удирдлагад танилцуулна.

3.11.10. Үнэт цаасны арилжааг түр зогсоосон хугацаа нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 21.7-д заасан 2 сараас хэтэрч буй эсэхэд хяналт тавьж, хэтэрсэн нөхцөлд түр зогсоох шийдвэр гаргасан улсын байцаагчид мэдэгдэнэ.

3.12. Үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагаас ирүүлэх дор дурьдсан мэдээлэлтэй холбоотой дараах хяналтын ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.12.1. Үнэт цаасны хадгаламж дахь нэгдсэн мэдээллийг бусад мэдээлэлтэй тулгаж, зөрүүтэй байгаа эсэхийг хянана;

3.12.2. Үнэт цаасны хадгаламжийн хэмжээний өөрчлөлттэй холбоотой мэдээлэлд үндэслэн үнэт цаасны бүртгэлд шинээр үнэт цаас бүртгэх, хасах, бүртгэлд өөрчлөлт оруулах тухай Хорооны шийдвэрийн биелэлтийг хянана. Тухайн үнэт цаас гаргагч компанийн хяналтыг хариуцсан мэргэжилтэн уг үнэт цаасны хадгаламжид орсон өөрчлөлт нь хууль тогтоомж, Хорооны шийдвэртэй нийцэж буй эсэхийг хянана;

3.12.3. Үнэт цаасны хадгаламж дахь мөнгөн хөрөнгийн гүйлгээ, үлдэгдлийн мэдээллийг брокер, дилерийн компаниас ирүүлсэн харилцагчийн дансан дах мөнгөн хөрөнгийн гүйлгээний мэдээтэй тулган мөнгөн хөрөнгийн гүйлгээ зохих журмын дагуу явж буй эсэхийг нягтална;

3.12.4. Үнэт цаасны хадгаламж дахь мөнгөн хөрөнгийн байршлын тухай мэдээ болон төвлөрсөн хадгаламж дахь мөнгөн хөрөнгийг шилжүүлэн байршуулсан тухай мэдээнд үндэслэн харилцагчдын мөнгөн хөрөнгийн байршилд гарсан өөрчлөлт нь холбогдох журамд нийцэж байгаа эсэх, шилжилтийн үндэслэлийг хянана;

3.12.5. Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг арилжааны бусаар шилжүүлсэн гүйлгээний мэдээнд үндэслэн нэгдсэн судалгаа гаргаж байх бөгөөд, шаардлагатай гэж үзвэл зарим гүйлгээ хууль журамд нийцэж байгаа эсэхийг түүвэрлэн шалгаж байна. Ямар компанийн хувьцаа арилжааны бусаар шилжсэн тухай мэдээллийг компани хариуцсан мэргэжилтэнд тухай бүр өгч, хувийн хэргийн мэдээллийн санд оруулж байна.

3.12.6. Арилжааны болон гүйлгээний шимтгэлийн судалгааг сар бүр нэгтгэн Хорооны Тамгын газарт шилжүүлэхээс гадна мэргэжлийн байгууллагаас Хороонд төлөх зохицуулалт үйлчилгээний хөлсний төлөлтийг хянана;

3.12.7. Үнэт цаасны хадгаламжийн дансыг шинэ болон холболтын данс нээсэн тухай мэдээллийг сараар нэгтгэж, энэ талаар брокер, дилерийн үйл ажиллагаа эрхэлж буй компаниас ирүүлсэн мэдээлэлтэй тулган, зөрүү болон зөрчлийг хянана;

3.12.8. Хувьцаат компанийн нийт гаргасан хувьцааны 5-аас дээш хувийн багц хувьцаа эзэмшигчдийн мэдээллийг хувьцаа эзэмшигчдээс Хороонд ирүүлсэн мэдэгдэлийн талаарх мэдээлэлтэй тулгаж, зөрүү болон зөрчлийг хянан, мэдэгдэл өгөөгүй этгээдэд Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ. Мэдэгдэл өгөх үүргээ зохих ёсоор хэрэгжүүлээгүй иргэдийн мэдээллийг нийтэд мэдээлнэ;

3.12.9. ХК-ийн ногдол ашгийн тараалтын тайлангийн нэгтгэлийг мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, гүйлгээний мэдээтэй тулган шалгаж, ногдол ашиг тараалтын байдалд хяналт тавин илэрсэн зөрчлийг арилгаж холбогдох мэдээллийг тухайн компанийн хувийн хэрэгт оруулна;

3.12.10. Засгийн газрын бондын хүү, үндсэн төлбөрийн мэдээг үндэслэн төлбөр хугацаандаа хийгдэж байгаа эсэхэд хяналт тавина;

3.12.11. Компанийн бондын хүү, үндсэн төлбөрийн мэдээг үндэслэн төлбөр хугацаандаа хийгдэж байгаа эсэхэд хяналт тавьж, төлбөрийн явцын талаарх мэдээллийг бонд гаргасан компанийн хувийн хэрэгт оруулна;

3.12.12. Үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар барьцаалсан үнэт цаасны талаарх мэдээллийг улирлаар нэгтгэн судалж, холбогдох мэдээллийг холбогдох компанийн хувийн хэрэгт оруулна;

3.12.13. Бүртгэлээс хасагдсан үнэт цаас эзэмшигчтэй тооцоо хийсэн тайланг үндэслэн үнэт цаасыг бүртгэлээс хасах тухай Хорооны шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавина;

3.12.14. Хууль хяналтын байгууллагын шийдвэрээр үнэт цаас тусгаарласан тухай мэдээг нэгтгэж, судалгаа гаргахын зэрэгцээ, холбогдох мэдээллийг тухайн компанийн хувийн хэрэгт оруулна.

3.12.15. Хороо, улсын байцаагчийн шийдвэрээр аль нэг этгээдийн өмчлөлийн үнэт цаасыг түр тусгаарласан тухай мэдээг Хорооны Ажлын албанаас гаргасан мэдээтэй тулган, үнэт цаасыг түр тусгаарласан үндэслэл, тусгаарлах болсон нөхцөл байдал арилсан эсэх, тусгаарлалтыг хүчингүй болгох эсэхэд хяналт тавих үүрэгтэй улсын байцаагч хяналт тавина;

3.12.16. Хороо, улсын байцаагчийн шийдвэрээр үнэт цаасны хадгаламж дах дансыг түр хаасан тухай мэдээллийг Хорооны Ажлын албанаас гаргасан мэдээлэлтэй тулгаж, зөрүү болон зөрчлийг хянахаас гадна, данс хаасан үндэслэл, данс хаасныг хүчингүй болгох нөхцөл бүрдсэн эсэхэд хяналт тавина;

3.12.17. Үнэт цаасны төлбөр тооцооны мэдээллийг брокер, дилерийн үйл ажиллагаа эрхэлж буй компаниас ирүүлэх харилцагчийн төлбөр тооцооны мэдээлэлтэй тулган брокер, дилерийн компанийн зуучлалаар харилцагчийн өмчлөлд шилжүүлж буй мөнгөн хөрөнгийн гүйлгээнд хяналт тавина.

3.13. Брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагаас ирүүлэх дор дурдсан мэдээлэлтэй холбогдох дараах хяналтыг хэрэгжүүлнэ:

3.13.1. Компанийн танилцуулга, түүнд оруулах өөрчлөлтийг Хороонд хадгалагдаж байгаа хувийн хэрэг дэх мэдээлэлтэй тулгаж, үнэн зөв мэдээлэл өгч буй эсэхэд хяналт тавина;

3.13.2. Компанийн арилжааны тухай мэдээллийг тухайн компанийн хувийн хэрэгт оруулж, уг мэдээллийг арилжаа эрхэлж буй байгууллагаас ирүүлсэн мэдээлэлтэй тулгаж, нийцэж буй эсэхэд хяналт тавихаас гадна, нэгдсэн судалгааг хагас жил тутам гаргана;

3.13.3. Ногдол ашиг тараалтын тайланг үнэт цаасны төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхэлж буй байгууллага болон тухайн ногдол ашгийг тарааж буй компаниас ирүүлсэн мэдээлэлтэй тулгаж, зөрүү болон зөрчил байгаа эсэхийг хянахаас гадна уг мэдээллийг тухайн мэргэжлийн байгууллагын хувийн хэрэгт оруулна;

3.13.4. Бүртгэлээс хасагдсан үнэт цаасыг эзэмшиж байгаа иргэн, хуулийн этгээдтэй тооцоо хийсэн тайланг үнэт цаасны төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагаас ирүүлсэн мэдээлэлтэй тулган шалгаж, хяналт тавина;

3.13.5. Хувьцаат компанийн хурлыг зохион байгуулсан тухай мэдээллийг тухайн хувьцаат компаниас ирүүлсэн мэдээлэлтэй тулгаж, зөрчил гарсан эсэхийг хянахын зэрэгцээ, мэдээллийг хувьцаат компани болон тухайн брокер, дилерийн компанийн хувийн хэрэгт оруулна;

3.13.6. Харилцагчдад шинээр болон холболтын данс нээсэн тухай мэдээллийг үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагаас ирүүлсэн

мэдээлэлтэй тулгаж, зөрүү болон зөрчлийг хянан, дүнгийн талаарх мэдээллийг тухайн үйлчилгээг үзүүлсэн брокер, дилерийн компанийн хувийн хэрэгт оруулна;

3.13.7. Харилцагчдын данс хооронд хөрөнгө шилжүүлсэн тухай мэдээг үнэт цаасны төлбөр, тооцоо, хадгаламжийн үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагаас ирүүлсэн мэдээлэлтэй тулгаж, зөрчилтэй эсэхийг хянан, дүнг брокер, дилерийн компанийн хувийн хэрэгт оруулна. Тухайн брокер, дилерийн компанийн хяналтыг хариуцсан мэргэжилтэн улиралд нэгээс доошгүй удаа харилцагчийн данс хооронд хөрөнгө шилжүүлсэн гүйлгээний баримтын болон үндэслэлийн шалгалтыг хийнэ;

3.13.8. Харилцагчдын дансан дахь мөнгөн хөрөнгийн гүйлгээний мэдээллийг үнэт цаасны төлбөр, тооцоо, хадгаламжийн үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагаас ирүүлсэн мэдээлэлтэй тулгаж, зөрүүг болон зөрчлийг хянан, дүнг брокер, дилерийн компанийн хувийн хэрэгт оруулна;

3.13.9. Андеррайтерийн үйлчилгээ үзүүлсэн тухай мэдээллийг үндэслэн Хорооноос тусгай зөвшөөрөл авсан эсэх, үйл ажиллагааг зохих журмын дагуу гүйцэтгэж буй эсэхэд хяналт тавьж мэдээллийг хувийн хэрэгт нь оруулна;

3.13.10. Өөрийн хөрөнгөөр хийсэн арилжааны мэдээллийг тэдгээрийн орлогын тайлантай тулгаж, орлогоо зөв тодорхойлсон эсэх, харилцагчийн захиалгыг өөрийн захиалгын өмнө биелүүлж байсан эсэх, сонирхлын зөрчил бүхий байдал үүссэн үед энэ тухай харилцагчид мэдэгдэх үүргээ хэрхэн биелүүлсэн, хуурамч, давхар гүйлгээ хийж байгаа эсэхэд хяналт тавина;

3.13.11. Компанийн эрх бүхий албан тушаалтан, ажилтнуудын нэгдмэл сонирхолтой этгээдийн тухай мэдээлэлд үндэслэн харилцагчийн захиалгыг түрүүнд биелүүлэх, сонирхлын зөрчил үүссэн үед харилцагчид мэдэгдэх зэрэг үүргээ хэрхэн биелүүлсэнд хуурамч, давхар гүйлгээ хийж байгаа эсэхэд хяналт тавина;

3.13.12. Компанийн эрх бүхий албан тушаалтан өөрчлөгдсөн тухай мэдээлэлд үндэслэн шинээр томилогдож буй иргэн үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрхтэй эсэхэд хяналт тавина;

3.13.13. Компанийн оршин байх хаяг, байршил өөрчлөгдсөн тухай мэдээлэлд үндэслэн харилцагчдаа мэдээлсэн эсэх, шинэ байршил дээрээ үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд хяналт тавина;

3.13.14. Компанийн салбарын тухай мэдээлэлд үндэслэн Хорооноос салбар байгуулах зөвшөөрөл авсан эсэх, уг салбар нь тогтмол үйл ажиллагаа явуулж буй эсэхэд хяналт тавина;

3.13.15. Компаниас ирүүлсэн хувь нийлүүлэгчдийн хурлын тэмдэглэл, шийдвэрүүд нь хууль тогтоомж, компанийн дүрэмд нийцэж байгаа эсэхийг хянана;

3.13.16. Компанийн жил, улирлын санхүүгийн тайланг, холбогдох тайлбар, тодруулгын хамт хүлээн авч, санхүүгийн байдал, зохистой харьцааны үзүүлэлтийн биелэлтэд хяналт тавьж, нэгтгэн, дүнг Хорооны удирдлагад танилцуулж, нэгдсэн мэдээллийг нийтэд мэдээллэнэ.

3.14. Үнэт цаас гаргагчаас ирүүлэх мэдээлэлтэй холбогдуулан дараах хяналтын ажиллагааг хэрэгжүүлж мэдээллийг хувийн хэрэгт оруулна.

3.14.1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, түүний хөдөлгөөний тухай мэдээлэлд үндэслэн ТУЗ-ийн гишүүдийг хууль тогтоомжоор тогтоосон журмын дагуу сонгосон эсэх, гишүүд нь “Компанийн засаглалын кодекс”-т заасан шалгуурыг хангаж байгаа эсэхэд хяналт тавина.

3.14.2. ХК-ийн их хэмжээний хэлцэл хийсэн тухай мэдээлэлд үндэслэн уг хэлцлийг хуульд нийцүүлэн эрх бүхий удирдах байгууллагын хурлаар шийдвэрлэсэн

эсэх, энэ хэлцлийг хийсэнтэй холбогдон компанийн санхүүгийн байдал, төлбөрийн чадварт мэдэгдэхүйц өөрчлөлт орсон бол энэ талаар зээлдүүлэгчдэд мэдэгдсэн эсэхэд хяналт тавина.

3.14.3. ХК-ийн сонирхлын зөрчилтэй хэлцэл хийсэн тухай мэдээлэлд үндэслэн уг хэлцлийг хуульд нийцүүлэн эрх бүхий удирдах байгууллагын хурлаар хараат бус гишүүдийн саналаар шийдвэрлэсэн эсэх, энэ хэлцлийн талаар хувь нийлүүлэгчдэд мэдээлэл үүргээ хэрэгжүүлсэн эсэхэд хяналт тавина

3.14.4. ХК-ийн ногдол ашиг хуваарилах шийдвэр, ногдол ашиг тараасан тайланд үндэслэн нийтэд зохих ёсоор мэдээлсэн эсэх, ногдол ашгийг зохих журмын дагуу хугацаандаа тараасан эсэх, тараагдаагүй үлдэгдлийг санхүүгийн тайланд өр болгон тусгасан эсэхийг хянаж, нэгдсэн судалгаа хийж Хорооны удирдлагад танилцуулна;

3.14.5. ХК өөрийн үнэт цаасыг худалдан авсан, худалдсан тухай мэдээлэлд үндэслэн уг ажиллагааг хууль, журамд нийцүүлэн гүйцэтгэсэн эсэхийг хянана.

3.14.6. ХК-ийн эрх бүхий албан тушаалтны өмчлөлд байгаа хувьцааны багцад өөрчлөлт гарсан тухай мэдээлэлд үндэслэн хуульд заасан мэдэгдлийг ирүүлсэн эсэх, ТУЗ-ийн хараат бус гишүүн хувьцаа эзэмшигч болсон эсэх, хувьцааны багц эзэмшигч өөрчлөгдсөн эсэх зэрэгт хяналт тавина

3.14.7. ХК нь охин, хараат компанитай болсон, охин болон хараат компанийн хяналтыг хэрхэн хэрэгжүүлж буй мэдээлэлд үндэслэн энэ асуудлыг хууль, журамд нийцүүлэн шийдвэрлэсэн эсэхэд хяналт тавина.

3.14.8. ХК-ийн төрийн /орон нутгийн/ өмчлөлийн хувьцаа худалдагдсан тухай мэдээлэлд үндэслэн бусад хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэх арга хэмжээг ТУЗ-өөс авч хэрэгжүүлсэн эсэхэд хяналт тавина

3.14.9. ХК-ийн хувьцааны хяналтыг багцыг нэгдмэл сонирхолтой этгээд эзэмших болсон тухай мэдээлэлд үндэслэн тэдгээр этгээд нь хууль тогтоомжоор бусад хувьцаа эзэмшигчдийн өмнө хүлээсэн үүргээ хэрхэн хэрэгжүүлсэн эсэхэд хяналт тавина.

3.14.10. ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл компанийг өөрчлөн байгуулах төслийг баталсан тухай мэдээлэлд үндэслэн уг мэдээллийг зохих журмын дагуу хувьцаа эзэмшигчиддээ хүргэсэн эсэхэд хяналт тавьж, Хорооны веб хуудсаар нийтэд мэдээлнэ.

3.14.11. Компанийн томоохон зээлдүүлэгчид, харилцагчдын тухай мэдээлэлд үндэслэн сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдэж байгаа эсэх, компанийн ТУЗ-д томоохон зээлдүүлэгчид, харилцагчдын төлөөлөл байгаа эсэхэд хяналт тавина.

3.14.12. Компанийн нэр, төв захиргааны оршин байх газар өөрчлөгдсөн тухай мэдээлэлд үндэслэн энэ тухай нийтэд мэдээлсэн эсэх, шинэ байршилд үйл ажиллагаа явуулж буй эсэх, холбогдох өөрчлөлтийг Улсын бүртгэлийн албанд бүртгүүлсэн эсэхэд хяналт тавина. Мэдээллийг хувийн хэрэгт нь оруулна;

3.14.13. Компанийн салбар, төлөөлөгчийн газрын тухай мэдээлэлд үндэслэн салбар, төлөөлөгчийн газрыг байгуулах шийдвэрийг компанийн дүрмийн дагуу гаргасан эсэх, холбогдох өөрчлөлтийг хийсэн эсэх, Улсын бүртгэлийн албанд бүртгүүлсэн эсэх, уг салбар төлөөлөгчийн газар үйл ажиллагаа явуулж буй эсэхэд хяналт тавина.

3.14.14. Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлд гарсан өөрчлөлтийн тухай мэдээлэлд үндэслэн асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэсэн эсэх, Улсын бүртгэлийн албанд бүртгүүлсэн эсэхэд хяналт тавина

3.14.15. Компанийн аудиторыг сонгон гэрээ байгуулсан, өөрчилсөн тухай мэдээлэлд үндэслэн хараат бус байх шаардлагыг хангаж байгаа эсэхэд хяналт тавина

3.14.16. Компанийн дүрэмд орсон өөрчлөлтийн тухай мэдээлэлд үндэслэн дүрмийн өөрчлөлт нь Компанийн тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нийцэж байгаа эсэхэд хяналт тавина.

3.14.17. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ /дүрмийн сан/-г нэмэгдүүлэх, хорогдуулах тухай мэдээлэлд үндэслэн шийдвэрийн төслийг ТУЗ баталсны үндсэн дээр шийдвэрийг хууль, компанийн дүрмийн дагуу гаргасан эсэхэд хяналт тавина.

3.14.18. Компанийн үл хөдлөх хөрөнгийг худалдах, барьцаалсан болон бусад хэлбэрээр бусдад шилжүүлсэн тухай мэдээлэлд үндэслэн уг шийдвэр, ажиллагаа нь хууль тогтоомж, компанийн дүрмийн дагуу гаргасан эсэх, их хэмжээний хэлцэлд хамаарах эсэхэд хяналт тавина.

3.14.19. Компанийн үйл ажиллагаа, хяналтын багц эзэмшигчид болон ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтнуудын үйлдэлтэй холбоотой асуудлаар хууль хяналтын байгууллагад хэрэг үүсгэсэн, эсхүл тэдгээр этгээд гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдож, хуулийн дагуу шийтгэгдсэн тухай мэдээллийг үндэслэн нийтэд мэдээлнэ.

3.14.20. Нийтэд санал болгон шинээр болон нэмж үнэт цаас гаргах төслийг ТУЗ, хувь нийлүүлэгчдийн хурлаар баталсан тухай мэдээлэлд үндэслэн шийдвэрийг хууль, компанийн дүрмийн дагуу гаргасан эсэхийг хянаж, мэдээллийг Хорооны веб хуудсанд байгаа ХК-ийн танилцуулгад тавина. Мөн ХК-ийн хувийн хэрэгт хадгална. Төсөл болон холбогдох баримтыг Хороонд хугацаанд ирүүлж, үнэт цаас бүртгүүлэх хүсэлтээ гаргасан эсэхийг хянана.

3.14.21. Компанийн санхүүгийн тайлан, Хорооноос тогтоосон нэмэлт, тайлбар, тодруулгыг үндэслэн тухайн компанийн санхүүгийн байдал, бусад үзүүлэлтийн биелэлтэд хяналт тавьж, дүнг Хорооны удирдлагад танилцуулна.

3.14.22. Компанийн үл хөдлөх хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ хийлгэсэн тухай тайланд үндэслэн санхүүгийн тайланд өөрчлөлт оруулсан эсэхэд хяналт тавина

3.14.23. Компанийн борлуулалтын орлогын 10-аас дээш хувийг эзэлдэг үйл ажиллагаатай холбогдох аливаа тусгай зөвшөөрөл /лиценз/ хүчингүй болсон, түүнийг худалдсан, барьцаалсан, аливаа хэлбэрээр бусдад шилжүүлсэн тухай мэдээлэлд үндэслэн уг шийдвэр, ажиллагаа нь хууль тогтоомж болон компанийн дүрэм журмын дагуу гүйцэтгэгдсэн эсэхэд хяналт тавина.

3.14.24. Компанийн бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлд гарсан томоохон өөрчлөлт, үүнтэй холбогдон үүсч болох эрсдэлийн тухай мэдээллийг шаардлагатай гэж үзвэл нийтэд мэдээллэнэ;

3.14.25. Нийтэд санал болгон гаргасан үнэт цаасны гүйлгээ болон арилжааны тайланг үндэслэн үнэт цаас бүртгэх тухай Хорооны шийдвэр, арилжааны ханш тогтоолтын явцад хяналт тавьж,

3.14.26. Хувь нийлүүлэгчдийн ээлжит болон ээлжит бус хурал хуралдуулах тухай мэдэгдэлд үндэслэн ээлжит хурлыг хуулиар тогтоосон хугацаанд хуралдуулахаар зарласан эсэх, ээлжит бус хурлыг эрх бүхий этгээд зарлаж байгаа эсэхэд хяналт тавина.

3.14.27. Хувь нийлүүлэгчдийн ээлжит болон ээлжит бус хурлын тэмдэглэл, шийдвэр, компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт, ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан, Хянан шалгах зөвлөлийн тайланд үндэслэн хурлын ирц, хэлэлцсэн асуудал, гаргасан шийдвэр нь хууль, компанийн дүрэмд нийцэж байгаа эсэхийг хянаж,

3.15. Хорооны Ажлын албанаас дор дурдсан судалгааг гүйцэтгэж, холбогдох мэдээллийг мэдээллийн санд оруулна:

3.15.1. Зах зээл дээр үйл ажиллагаа явуулж байгаа тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагын танилцуулга, судалгаа, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрх авсан иргэдийн судалгааг дараа сарын эхний долоо хоногт багтаан;

3.15.2. Үнэт цаасны бүртгэлд шинээр бүртгэгдсэн хувьцаа, нэмж гаргасан хувьцаа, хувьцааны бүртгэлд өөрчлөлт орсон, бүртгэлээс хасагдсан компанийн нэгдсэн судалгааг дараа сарын эхний долоо хоногт багтаан;

3.15.3. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгосон, түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон, шинээр үнэт цаас бүртгэсэн, бүртгэлд өөрчлөлт оруулсан, бүртгэлээс хассан, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгосон тухай мэдээллийг шийдвэр гарснаас хойш ажлын 5 хоногт багтаан;

3.15.4. Нийтэд санал болгон үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны тухай нэгдсэн судалгаа, тухайн үнэт цаасны танилцуулгыг дараа сарын эхний долоо хоногт багтаан;

3.15.5. ХК-ийн хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлын тухай мэдээллийг тухайн жилийн хоёрдугаар улирлын эхний сард багтаан, бусад хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийн талаарх судалгааг жил бүрийн эхний улиралд багтаан;

3.15.6. Тендер санал зарлахыг зөвшөөрсөн Хорооны шийдвэрийн танилцуулгыг шийдвэр гарснаас хойш ажлын 5 хоногт багтаан;

3.15.7. Зах зээлийн мэргэжлийн оролцогчдын санхүүгийн тайлангийн нэгтгэлийг Хороонд танилцуулснаас хойш ажлын 5 хоногт багтаан;

3.15.8. Мэргэжлийн оролцогч байгууллага, үнэт цаас гаргагч, тэдгээрийн ажилтан, эрх бүхий албан тушаалтны гаргасан зөрчил, хүлээлгэсэн хариуцлагын тухай мэдээлэл, судалгааг сараар гаргаж, мэдээллийг дараа сарын эхний долоо хоногт багтаан;

3.15.9. Хороо, улсын байцаагчийн шийдвэрээр үнэт цаасыг түр тусгаарласан, дансыг хаасан, арилжааг зогсоосон, хэлцэл буцаасан, захиргааны хариуцлага хүлээлгэсэн тухай мэдээ, судалгааг сар бүр гаргаж Хорооны удирдлагад танилцуулсны үндсэн дээр мэдээллийг дараа сарын эхний долоо хоногт багтаан;

3.15.10. Хороонд ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн шийдвэрлэлтийн судалгааг Хорооны удирдлагад танилцуулж шаардлага гарвал мэдээллийн санд оруулна;

3.15.11. Хорооноос хэрэгжүүлж буй зохицуулалтын болон хяналтын ажиллагааны талаарх нэгдсэн судалгааг улирал бүрээр гаргаж Хорооны удирдлагад танилцуулсаны үндсэн дээр дараа улирлын эхний сард багтаан

3.15.12. Хороо, түүний Ажлын албаны зүгээс шаардлагатай гэж үзсэн бусад мэдээ, мэдээлэл, судалгааг тухай бүр Хорооны Албаны даргын шийдвэрээр.

ДӨРӨВ. Мэдээллийн сан дахь мэдээллийг ашиглах, мэдээллийг олон нийтэд мэдээллэх

4.1. Мэдээллийн сан дахь мэдээллийг хууль, тогтоомжийн хүрээнд нийтийн эрх ашигт нийцүүлэн хөрөнгийн зах зээл дэх мэдээллийн нээлттэй байдлыг бий болгох, олон нийтийн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх, эрдэм, шинжилгээ, судалгаа хийх боломжийг бүрдүүлэх, зохицуулах байгууллагын хяналтын чиг үүргийг шуурхай, үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор ашиглана.

4.2. Мэдээллийн сан дахь мэдээллийг хувийн сонирхлоор хууль бус үйлдэлд ашиглахыг хориглоно.

4.3. Мэдээллийн санд ирүүлсэн мэдээллээс энэхүү журмын нэгдүгээр хавсралтад нийтэд тогтмол мэдээлэхээр заасан мэдээллийг Хорооны веб хуудсаар дамжуулан үнэ төлбөргүй нийтийн хүртээл болгоно. Уг мэдээллийг хэвлэмэл хэлбэрээр нийтэд хүргэх тохиолдолд гарсан зардлын хэмжээгээр төлбөр тогтоож болох ба төлбөрийг Хорооны Ажлын албаны даргын тушаалаар тогтооно.

4.4. Энэхүү журмын нэгдүгээр хавсралтад нийтэд тогтмол мэдээлэхээр зааснаас бусад, хуулиар нийтэд мэдээлэхийг хориглоогүй бөгөөд уг мэдээллийг гаргахад тодорхой шүүлт, судалгаа, харьцуулалт, дүгнэлт болон шинжилгээ шаардлагатай тухайлсан мэдээллийг төлбөртэй нийтийн хүртээл болгоно. Төлбөрийн хэмжээг Хорооны Ажлын албаны даргын тушаалаар тогтооно.

4.5. Мэдээллийн сангийн үйл ажиллагааг хариуцсан нэгж нь энэхүү журмын дагуу нийтийн хүртээл болгох сар тутмын мэдээллийн нэгтгэл, мэдээллийн сангийн үйл ажиллагаа, мэдээлэл ирүүлэх үүрэг бүхий иргэн, хуулийн этгээдээс мэдээллийг тогтоосон хуваарийн дагуу ирүүлж буй эсэх асуудлыг тухайн сарын Хорооны хуралдаанд, тухайн сард Хороо хуралдаагүй бол дараа сарын хуралдаанд тухай бүр танилцуулж байна.

4.6. Энэхүү журмаар нийтэд тогтмол мэдээлэхээр заасан мэдээллийн өдрөөр гаргах мэдээллийг дараа өдрийн ажлын цаг эхэлснээс хойш 2 цагийн дотор, сараар гаргах нэгтгэлийг дараа сарын 10-ны дотор, жилээр гаргах нэгтгэлийг дараа жилийн 2 дугаар сарын 1-ний дотор гаргаж нийтийн хүртээл болгоно.

4.7. Энэхүү журмын дагуу мэдээллийн журмаас гаргах мэдээлэл, Хорооны дотоод хэрэгцээнд гаргах судалгаа, шинжилгээг мэдээллийн сангийн үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн эрхлэн гаргана.

ТАВ. Мэдээллийн сан дахь мэдээллийн хадгалалт

5.1. Мэдээллийн сан дахь мэдээллийн сан хөмрөгийг электрон болон цаасан хэлбэрээр хадгалах бөгөөд үүний аюулгүй байдлыг мэдээллийн сангийн үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн хариуцна.

5.2. Мэдээллийн сангийн үйл ажиллагаа хариуцсан нэгж нь тухайн жилийн туршид мэдээллийн санд төвлөрсөн цаасан хэлбэрийн мэдээллийн сан хөмрөгийг архивын дүрэм журмын дагуу эмхтгэж, электрон сан хөмрөгийг мэдээлэл хадгалах зориулалт бүхий хуурцагт хуулбарлан дараа жилийн 1 дүгээр сарын дотор Хорооны архивт хүлээлгэн өгнө.

ЗУРГАА. Хариуцлага

6.1. Хууль тогтоомж, Хорооны шийдвэр болон энэ журмаар мэдээллийн санд ирүүлэхээр заасан мэдээллийг тогтоосон хугацаанд, зохих маягтын дагуу, үнэн зөвөөр, бүрэн ирүүлээгүй, өөрийн зүгээс нийтэд мэдээлэх мэдээллийг нийтэд мэдээлээгүй иргэн, хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

1	Арилжаа явагдсан өдөр	
2	Үнэт цаас нь бүртгэгдсэн компанийн тоо <i>Үүнээс: Төрийн өмчийн Төрийн өмчийн оролцоотой Хувийн өмчийн</i>	
3	Зах зээлийн нийт үнэлгээ /төгрөг/	
4	Үнэт цаасны гүйлгээний дүн /төгрөг/ <i>Үүнээс: Компанийн хувьцаа Засгийн газрын бонд Компанийн бонд</i>	
5	Арилжигдсан үнэт цаасны тоо <i>Үүнээс: Компанийн хувьцаа Засгийн газрын бонд Компанийн бонд</i>	
6	Дундаж ханш <i>Үүнээс: Компанийн хувьцаа Засгийн газрын бонд Компанийн бонд</i>	
7	ТОП-20 индекс <i>Дундаж Хамгийн их Хамгийн бага Хаалт</i>	
8	Төвлөрсөн хадгаламжинд нээгдсэн данс/тухайн сард/ <i>Үүнээс: Аж ахуй нэгж байгууллага Хувь хүн</i>	
9	Хугацааны эцэст	
10	Үүнээс: Аж ахуй нэгж байгууллага хувь хүн Брокер, дилерийн компанийн тоо	
11	андеррайтерийн компанийн тоо	

Энэ мэдээг дараа оны 1 дүгээр сарын 20-ны дотор мэдээллийн санд ирүүлнэ.

АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААНЫ МЭДЭЭ

үнэт цаас		нэрлэсэн үнэ	арилжаалсан тоо	арилжааны үнийн дүн	ханш			арилжааны огноо		хувьцааны 5%аас дээш хувийг худалдан авсан	
нэр	төрөл				нээлт	хаалт	дундаж	эхэлсэн	дууссан	нэр	дансны дугаар

Энэ мэдээг тодорхой үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа дуудсаны дараа өдөр МНС-д ирүүлнэ.

"Үнэт цаасны мэдээллийн нэгдсэн сангийн тухай"
журмын хавсралт МС-1-3-1 маягт

ҮНЭТ ЦААСНЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААНЫ МЭДЭЭ

№	Үнэт цаасны код	Үнэт цаасны нэр	Хэлцлийн тоо	Арилжигдсан ширхэг	ханш		Ханшийн өөрчлөлт	Дээд үнэ	Доод үнэ
					Нээлт	Хаалт			

Энэ мэдээг өдөр бүр МНС-д ирүүлнэ

ХАНШИЙН ХЭЛБЭЛЗЭЛ ИХТЭЙ ҮНЭТ ЦААС (САРД)
ХАНШИЙН ӨСӨЛТТЭЙ ҮНЭТ ЦААС

	Үнэт цаас	Арилжигдсан ширхэг	Хаалтын ханш		Ханшийн өөрчлөлт	Өөрчлөлт хувиар
			Сарын эхэнд	Сарын эцэст		
1						
2						
3						
4						
5						
6						
7						
8						
9						
10						
11						
12						
13						
14						
15						
16						
17						
18						
19						
20						

ХАНШИЙН БУУРАЛТТАЙ ҮНЭТ ЦААС

	Үнэт цаас	Арилжигдсан ширхэг	Хаалтын ханш		Ханшийн өөрчлөлт	Өөрчлөлт хувиар
			Сарын эхэнд	Сарын эцэст		
1						
2						
3						
4						
5						
6						
7						
8						
9						
10						
11						
12						
13						
14						
15						
16						
17						
18						
19						
20						

Энэ мэдээг сар бүр гаргаж, дараа сарын 3-ны дотор мэдээллийн санд ирүүлнэ

БҮРТГЭЛТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН СУДАЛГАА

хувьцаат компанийн нэр	үнэт цаасны тоо	үүнээс		тухайн сард арилжаалсан			бүртгэлийн хураамжийн өртэй эсэх, өртэй бол	үнэт цаасны ангилал
		энгийн хувьцаа	давуу эрхийн хувьцаа	тоо	үнийн дүн	хаалтын ханш		
<u>бүрэн хувьчлагдсан:</u> 1. 2. 3. 4.								
<u>Төрийн өмчийн оролцоотой:</u> 1. 2. 3. 4.								
<u>төрийн өмчийн:</u> 1. 2. 3. 4. ..								
<u>орон нутгийн өмчийн оролцоотой:</u> 1. 2. 3. 4. ..								
<u>орон нутгийн өмчийн:</u> 1. 2. 3. 4. ..								

Энэ мэдээг сар бүр гарган дараа сарын 5-ны дотор МНС-д ирүүлнэ

НОГДОЛ АШИГ ТАРААХААР ШИЙДВЭРЛЭСЭН
ХУВЬЦААТ КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

№	компанийн нэр	байршил	нийт гаргасан хувьцааны тоо	ногдол ашгийн хэмжээ / нэгж хувьцаанд төг /	ногдол алгаа тараасан хэлбэр	нийт хөрөнгө	тайланг үеийн татварын дараах цэвэр ашиг /мян.төг/

Судалгаа гаргасан: / /
Хянаж, баталгаажуулсан : / /

Энэ мэдээг улирал бүр гарган дараа улирлын эхний сарын 5-ны дотор МНС-д ирүүлнэ.

ТОП 20 БОЛОН САЛБАРЫН ИНДЕКСИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН МЭДЭЭ

ТОП 20			салбар А			салбар Б			салбар В			салбар Г		
сарын эхэнд	сарын эцэст	өөрчлөлт	сарын эхэнд	сарын эцэст	өөрчлөлт	сарын эхэнд	сарын эцэст	өөрчлөлт	сарын эхэнд	сарын эцэст	өөрчлөлт	сарын эхэнд	сарын эцэст	өөрчлөлт

ТОП 20 индексийн өөрчлөлтийн талаарх товч дүгнэлт:

Энэ мэдээллийг Монголын хөрөнгийн бирж сар бүр гарган дараа сарын 10-ны дотор МНС ирүүлнэ.

ГИШҮҮН БРОКЕР, ДИЛЕРИЙН КОМПАНИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

мэдээллийн байгууллагын нэр	тусгай зөвшөөрлийн төрөл	ажиллагсдын тоо	тухайн сарын үйл ажиллагааны мэдээ			
			арилжаанд орсон тухай	хийсэн арилжааны хэмжээ	зөрчил гаргасан эсэх	арилжааны дүнгээр эзэлсэн байр

Энэ мэдээг сар бүрийн үзүүлэлтээр гарган, дараах сарын 3-ны дотор мэдээллийн санд ирүүлнэ.

ШИНЭЭР БҮРТГЭГДСЭН ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

үнэт цаасны нэр	төрөл	тоо ширхэг	нэрлэсэн үнэ	үнийн дүн	бүртгэгдсэн өдөр	арилжааны эхлэл огноо

Энэ мэдээг шинээр үнэт цаас бүртгэсэн тухай бүр гаргаж, бүртгэлийн дараах ажлын өдөрт багтаан мэдээллийн санд ирүүлнэ.

ХОРОО, УЛСЫН БАЙЦААГЧИЙН ШИЙДВЭРЭЭР ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААГ ТҮР
ЗОГСООСОН, СЭРГЭЭСЭН МЭДЭЭЛЭЛ

Үнэт цаасны нэр	арилжааг түр зогсоох шийдвэр гаргасан этгээдийн нэр	Шийдвэрийн		арилжааг зогсоосон үндэслэл	сэргээсэн огноо
		дугаар	огноо		

Энэ мэдээг тухайн сард арилжааг зогсоосон, сэргээсэн бүх үнэт цаасыг хослуулан гаргаж дараа сарын 3-ны дотор мэдээллийн санд ирүүлнэ.

ҮНЭТ ЦААСНЫ КОМПАНИУДЫН ГҮЙЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ /тухайн өдрөөр/

№	Үнэт цаасны компанийн нэр	авсан үнэт цаас				зарсан үнэт цаас			
		ширхэг	хувиар	үнийн дүн	хувиар	ширхэг	хувиар	үнийн дүн	хувиар
	нийт								

Мэдээ гаргасан ://
 Мэдээг хянасан ://

Энэ мэдээг өдөр бүр тухайн ажлын өдрийн 17 цагт МНС-д ирүүлнэ.

ХЭЛЦЛИЙН НЭГДСЭН ТОВЧОО

хэлцэл	ҮЦ-ны код	үнэ	тоо ширхэг	ҮЦК		цаг
				авсан	зарсан	

Мэдээ гаргасан ://
Мэдээг хянасан ://

Энэ мэдээг өдөр бүр тухайн ажлын өдрийн 17 цагт МНС-д ирүүлнэ.

ХӨРӨНГИЙН БИРЖ/ ҮНЭТ ЦААСНЫ ХАДГАЛАМЖИЙН БАЙГУУЛЛАГА/ ҮНЭТ
ЦААСНЫ ТӨЛБӨР ТООЦООНЫ БАЙГУУЛЛАГЫН ТАНИЛЦУУЛГА

№	Үзүүлэлтүүд	Мэдээлэл
1	Улсын бүртгэлд бүртгүүлсэн огноо, гэрчилгээний дугаар	
2	Тусгай зөвшөөрлийн огноо, дугаар	
1	Байгуулагдсан огноо, шийдвэр	
3	Өөрчлөн байгуулагдсан огноо, шийдвэрийн дугаар	
4	Хувь нийлүүлсэн хөрөнгө, өмчийн хэлбэр, өмчлөгч	
5	ТУЗ-ийн дарга: овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	ТУЗ-ийн гишүүд:	
	1. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	2. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	3. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	4. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	5. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	6. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	7. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	8. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	9. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
6	Гүйцэтгэх захирал: овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	Албадын захирлууд:	
	1. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	

	2. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	3. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	4. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	

Энэ мэдээг мэдээллийн сан бүрдүүлж эхэлсэн үед бүрдүүлж, өөрчлөлт оруулсан тухай бүр нэмж өөрчлөлт оруулна.

САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үзүүлэлт	2005	2006	2007	2008				
				I	II	III	IV	Жилийн дун
Нийт хөрөнгө								
Эргэлтийн хөрөнгө								
Үүнээс Харилцагчдын мөнгөн хөрөнгө								
Эрсдэлийн сан								
Үндсэн хөрөнгө								
үүнээс: барилга								
Биет бус хөрөнгө								
Үүнээс: Програм хангамж								
Өөрийн хөрөнгө								
Өр төлбөр								
Борлуулалт								
Үүнээс: үндсэн үйл ажиллагааны								
Үйл ажиллагааны зардал								
Үйл ажиллагааны бус зардал								
Нийт ашиг								
Цэвэр ашиг								

ҮНЭТ ЦААСНЫ ХАДГАЛАМЖИЙН НЭГДСЭН МЭДЭЭЛЭЛ

Код	үнэт цаасны нэр	тоо ширхэг	нэрлэсэн үнэ	үнийн дүн	ЭЗЭМШИГЧИЙН ТОО			
					5-аас дээш хувь	33,3 -аас дээш хувь	10-аас дээш хувь	бүгд

Судалгаа гаргасан:

Судалгааг хянасан:

Энэ мэдээг сар бүр гарган дараа сарын 3-ны дотор МНС-д ирүүлнэ.

ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН МЭДЭЭЛЭЛ

№	код	Үнэт цаасны нэр	бүртгэлтэй үнэт цаасны тоо (сарын эхэнд)	зах зээлийн үнэлгээ	бүртгэлд орсон өөрчлөлт		бүртгэлтэй үнэт цаасны тоо	тайлбар	Хорооны тогтоолын		Арилжаа эрхлэх байгууллагын мэдэгдэл		төвлөрсөн хадгаламжийн өөрчлөлт орсон огноо
					нэмэгдсэн	хасагдсан			дугаар	огноо	дугаар	огноо	

Судалгаа гаргасан:

Судалгааг хянасан:

Энэ мэдээг сар бүрийн 5-ны дотор / e-mail-ээр / мэдээллийн нэгдсэн санд ирүүлнэ.

ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖ ДАХЬ МӨНГӨН ХӨРӨНГИЙН ГҮЙЛГЭЭ, ҮЛДЭГДЭЛИЙН
МЭДЭЭЛЭЛ (мян.төг)

№	БДК	Харилцагчийн тоо	Дансны эхний үлдэгдэл	Орлого			Харилцагчийн тоо	Зарлага		
				Кассаар	Харилцахаар	Данс хооронд		Кассаар	Харилцахаар	Данс хооронд

Судалгаа гаргасан: нябо

Судалгаа гаргасан:

Судалгааг хянасан:

Энэ мэдээг сар бүрийн 5–ны дотор мэдээллийн нэгдсэн санд ирүүлнэ.

ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖ ДАХЬ ХАРИЛЦАГЧДЫН
МӨНГӨН ХӨРӨНГИЙН БАЙРШЛЫН МЭДЭЭЛЭЛ

Мян.төг

эхний үлдэгдэл						орлого						зарлага						эцсийн үлдэгдэл											
арилжааны банкин дахь харилцах дансанд	арилжааны банкин дахь хадгаламжийн	касст бэлнээр	хадгаламжийн хайрцаг	бусад	бүгд	арилжааны банкин дахь харилцах дансанд	арилжааны банкин дахь хадгаламжийн	касст бэлнээр	хадгаламжийн хайрцаг	бусад	бүгд	арилжааны банкин дахь харилцах дансанд	арилжааны банкин дахь хадгаламжийн	касст бэлнээр	хадгаламжийн хайрцаг	бусад	бүгд	арилжааны банкин дахь харилцах дансанд	арилжааны банкин дахь хадгаламжийн	касст бэлнээр	хадгаламжийн хайрцаг	бусад	бүгд						

харилцах дансны үлдэгдэл	эхний үлдэгдэл	эцсийн үлдэгдэл
зоос банк		
хадгаламж банк		
голомт банк		
бусад		
бүгд		

харилцах дансны үлдэгдэл	эхний үлдэгдэл	эцсийн үлдэгдэл
зоос банк		
хадгаламж банк		
голомт банк		
бусад		
бүгд		

Сар бүр гарган дараа сарын 5-ны дотор МНС-д ирүүлнэ.

ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖ ДАХЬ ХАРИЛЦАГЧДЫН
МӨНГӨН ХӨРӨНГИЙГ ШИЛЖҮҮЛСЭН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

Мян.төг

харилцах дансны үлдэгдэл (банкны нэр)	эхний үлдэгдэл	эцсийн үлдэгдэл	шилжүүлсэн шалтгаан, шийдвэр гаргасан этгээдийн нэр, дугаар огноо
хадгаламжийн дансны үлдэгдэл (банкны нэр)	эхний үлдэгдэл	эцсийн үлдэгдэл	шилжүүлсэн бол шалтгаан, шийдвэр гаргасан этгээдийн нэр, шийдвэрийн дугаар огноо

Энэ мэдээг сар бүр гарган МНС-д ирүүлнэ.

ҮНЭТ ЦААСААР ГЭРЧЛЭГДСЭН ӨМЧЛӨХ ЭРХИЙГ
АРИЛЖААНЫ БУСААР ШИЛЖҮҮЛСЭН ГҮЙЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ

Үнэт цаасны нэр	Шилжүүлгийн төрөл									Хорооны шийдвэр, улсын байцаагчийн мэдэгдлээр	Төрийн өмчийн дуудлага худалдаагаар		
	Бэлэглэлээр			Өв залгамжлалаар			Шүүхийн шийдвэр, үүргийн гүйцэтгэл хангуулахаар				тоо	худалдсан үнэ	шимтгэлийн дүн
	тоо	шимтгэн тооцсон үнэ	шимтгэлийн дүн	тоо	шимтгэн тооцсон үнэ	шимтгэлийн дүн	тоо	шимтгэн тооцсон үнэ	шимтгэлийн дүн				

Энэ мэдээг сар бүр гарган Үнэт цаасны мэдээллийн нэгдсэн санд дараа сарын 3-ны дотор ирүүлнэ.

"Үнэт цаасны мэдээллийн нэгдсэн сангийн тухай"
журмын хавсралт МС-2-7-1 маягт

ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ БОЛОН ШИМТГЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ /анхдагч зах зээл/

Код	БДК-ийн нэр	Худалдан авсан			Худалдсан			МХБ-ийн шимтгэл	ҮЦТГТХТ-ийн шимтгэл	БДК-ийн шимтгэл	СЗХ-ны зохицуулалтын үйлчилгээний хөлс
		Ширхэг	Үнийн дүн	Шимтгэл	Ширхэг	Үнийн дүн	Шимтгэл				

"Үнэт цаасны мэдээллийн нэгдсэн сангийн тухай"
журмын хавсралт МС-2-7-2 маягт

ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ БОЛОН ШИМТГЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ /хоёрдогч зах зээл/

Код	БДК-ийн нэр	Худалдан авсан			Худалдсан			МХБ-ийн шимтгэл	ҮЦТГТХТ-ийн шимтгэл	БДК-ийн шимтгэл	СЗХ-ны зохицуулалтын үйлчилгээний хөлс
		Ширхэг	Үнийн дүн	Шимтгэл	Ширхэг	Үнийн дүн	Шимтгэл				

"Үнэт цаасны мэдээллийн нэгдсэн сангийн тухай"
журмын хавсралт МС-2-7-3 маягт

ЗАСГИЙН ГАЗРЫН БОНДЫН АРИЛЖААНЫ БОЛОН ШИМТГЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ /анхдагч зах зээл/

Код	БДК-ийн нэр	Худалдан авсан			Худалдсан			МХБ-ийн шимтгэл	ҮЦГТТХТ-ийн шимтгэл	БДК-ийн шимтгэл	СЗХ-ны зохицуулалтын үйлчилгээний хөлс
		Ширхэг	Үнийн дүн	Шимтгэл	Ширхэг	Үнийн дүн	Шимтгэл				

"Үнэт цаасны мэдээллийн нэгдсэн сангийн тухай"
журмын хавсралт МС-2-7-4 маягт

ЗАСГИЙН ГАЗРЫН БОНДЫН АРИЛЖААНЫ БОЛОН ШИМТГЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ /хоёрдогч зах зээл/

Код	БДК-ийн нэр	Худалдан авсан			Худалдсан			МХБ-ийн шимтгэл	ҮЦГТТХТ-ийн шимтгэл	БДК-ийн шимтгэл	СЗХ-ны зохицуулалтын үйлчилгээний хөлс
		Ширхэг	Үнийн дүн	Шимтгэл	Ширхэг	Үнийн дүн	Шимтгэл				

"Үнэт цаасны мэдээллийн нэгдсэн сангийн тухай"
журмын хавсралт МС-2-7-5 маягт

КОМПАНИЙН БОНДЫН АРИЛЖААНЫ БОЛОН ШИМТГЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ /анхдагч зах зээл/

Код	БДК-ийн нэр	Худалдан авсан			Худалдсан			МХБ-ийн шимтгэл	ҮЦТТТХТ-ийн шимтгэл	БДК-ийн шимтгэл	МХБ-ийн бүртгэлийн хураамж	СЗХ-ны зохицуулалтын үйлчилгээний хөлс
		Ширхэг	Үнийн дүн	Шимтгэл	Ширхэг	Үнийн дүн	Шимтгэл					

"Үнэт цаасны мэдээллийн нэгдсэн сангийн тухай"
журмын хавсралт МС-2-7-6 маягт

КОМПАНИЙН БОНДЫН АРИЛЖААНЫ БОЛОН ШИМТГЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ /хоёрдогч зах зээл/

Код	БДК-ийн нэр	Худалдан авсан			Худалдсан			МХБ-ийн шимтгэл	ҮЦТТТХТ-ийн шимтгэл	БДК-ийн шимтгэл	СЗХ-ны зохицуулалтын үйлчилгээний хөлс
		Ширхэг	Үнийн дүн	Шимтгэл	Ширхэг	Үнийн дүн	Шимтгэл				

Судалгаа гаргасан:/...../
Судалгаа хянасан:/...../

Энэ мэдээг сар бүрийн 5-ны дотор мэдээллийн нэгдсэн санд ирүүлнэ.

ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖИД НЭЭГДСЭН ДАНСНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ

№	БДК-ны код	ХОЭБ	Шинэ данс /Иргэд/		Шинэ данс / ААН/		Холболт	Нийт
			Монгол	Гадаад	Монгол	Гадаад		

Мэдээлэл гаргасан:..... /

Мэдээлэл хянасан: /

Энэ мэдээг сар бүрийн 5-ны дотор мэдээллийн нэгдсэн санд ирүүлнэ.

ХК-ИЙН НИЙТ ГАРГАСАН ХУВЬЦААНЫ 5 ХУВИАС ДЭЭШ БАГЦЫГ
ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ

.....
(Компанийн нэр)

Хувьцаа эзэмшигчдийн нэр	дансны дугаар	эзэмшиж буй хувьцааны		өнгөрсөн сараас өөрчлөлт	
		тоо	нийт хувьцааны эзлэх хувь	нэмэгдсэн	хасагдсан
1					
2					
3					
4					
5					

Мэдээлэл гаргасан: /

Мэдээлэл хянасан: /

Энэ мэдээг сар бүрийн 5-ны дотор мэдээллийн нэгдсэн санд
ирүүлнэ

ХУВЬЦААТ КОМПАНИЙН НОГДОЛ АШГИЙН ТАРААЛТЫН ТАЙЛАН

№	Компанийн нэр	Хувьцааны тоо		Ногдол ашгийн хэмжээ /нэгж хувьцаанд,төг/		ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчийн тоо	тараасан хэлбэр			Үлдэгдэл
		нийт гаргасан	ногдол ашиг олох	нэгж хувьцаа	нийт		дансанд байршуулсан	Б/ДК-р	бэлгээр	

Судалгаа гаргасан: захирал..... /...../

Энэ мэдээг сар бүр гарган дараа сарын 3-ны дотор МНС-д ирүүлнэ.

**ЗАСГИЙН ГАЗРЫН БОНДЫН ХҮҮ
ҮНДСЭН ТӨЛБӨРИЙН МЭДЭЭЛЭЛ**

Бондын төрөл	хугацаа	хүү (хямдралын хэмжээ)	нийт төлөгдөөгүй үлдэгдэл	төлөгдөх хугацаа болсон		төлөгдсөн	
				үндсэн төлбөр	хүү	үндсэн төлбөр	хүү

Энэ мэдээг сар бүрийн 3-ны дотор Мэдээллийн нэгдсэн санд ирүүлнэ.

КОМПАНИЙН БОНДЫН ХҮҮ
ҮНДСЭН ТӨЛБӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

Бондын төрөл	хугацаа	хүү (хямдралын хэмжээ)	нийт төлөгдөөгүй үлдэгдэл	төлөгдөх хугацаа болсон		төлөгдсөн	
				үндсэн төлбөр	хүү	үндсэн төлбөр	хүү

Энэ мэдээг сар бүрийн 3-ны дотор Мэдээллийн нэгдсэн санд ирүүлнэ

**ҮҮРГИЙН ГҮЙЦЭТГЭЛ ХАНГУУЛАХ ЗОРИЛГООР
 ЗЭЭЛИЙН БАРЬЦААНД ТУСГААРЛАСАН
 ҮНЭТ ЦААСНЫ МЭДЭЭ**

зээлдэгчийн нэр		
зээлдүүлэгчийн нэр		
барьцаалсан үнэг цаас	код	
	нэр	
	тоо	
	код	
	нэр	
	тоо	
	код	
	нэр	
	тоо	
зээлийн	хэмжээ	
	хугацаа	
	хүү	

Энэ судалгааг зээлдэгч нэг бүрээр сар бүр гарган, дараа сарын 3-ны дотор Хороонд ирүүлнэ.

